

The Baptist Tabernacle of Los Angeles

1329 South Hope Street, L.A. Civic Center

Mailing Address:
P. O. Box 15308
Los Angeles, CA 90015
Phone: (213) 744-9999

E-mail: rlhymersjr@sbcglobal.net
www.sermonsfortheworld.com
www.baptisttabernacle.com



Dr. R. L. Hymers, Jr.
Senior Pastor

Dr. Christopher L. Cagan
Associate Pastor

Dr. Kreighton L. Chan
Assistant Pastor

Арванхоёрдугаар сар, 2016

Эрхэм анд минь:

Манай чуулганы энэ жилийн гол үйл явдал бол Бурхан бидэнд сэргэлтийг хуучны арга барилаар илгээсэн явдал юм. Би гэр бүлийнхэнтэйгээ Мексикийн Канкунд байж байсан. Би нарлаг сайхан өдрүүдийнхээ нэгийг зочид буудалдаа 1949-өөс 1953 оны хооронд Шотландын хойд хэсгийн Левис Офф арал дээр болсон сэргэлтийн талаарх нэгэн номыг уншиж өнгөрөөсөн. Миний сэтгэл зүрх энэ номыг уншиж байх явцад сэргэлтийг авсан. Тэгээд би манай чуулганд сэргэлт ирүүлж өгөөч хэмээн шургуу залбирч эхэлсэн. Би буцаж ирээд гурван өдрийн турш номлол хийсэн бөгөөд хэдэн залуус үүгээр багтай авралыг олсон. Гэхдээ энэ зуны дараа жинхэнэ гол сэргэлт нь гэнэт тохиосон. Энэ бол Наймдугаар сарын 27-ны өдрийн Пүрэв гарагийн орой байсан. Би залуустаа Исаиа 64:1-3 дугаар ишлэл “Аяа, Та тэнгэрийг яран, доош бууж ирвэл...” (Исаиа 64:1) гэсэн хэсгийг цээжлээрэй гэж захисан байсан. Гурван залуу дээрх ишлэлийг цээжээрээ уншисан. Гэнэт нэг залуу нь хөл дээрээ үсрэн “Би гээгдсэн!” хэмээн орь дуу тависан. Тэр өвдөг сөгдөөд гашуудан уйлсаар байсан. Тэр орой дуу ч дуулаагүй, ямар ч тийм сэтгэл хөдөлгөсөн зүйл болоогүй байхад ингэсэн нь үнэхээр цагаа олоогүй юм шиг санагдаж байсан. Нэгдүгээр сар болон Наймдугаар сарын эдгээр хэдэн цугларалтад Бурхан бидэн дээр айлчлан ирсэн бөгөөд 22 залуус аврагдаж, 14 гаруй хүмүүс сэргэлт аван Сүнсээр дүүрсэн. Би үнэхээр хүчирхэг, ер бусын, миний мэдэхийн өнөөдөр хаана ч үзэгдэж байгаагүй тийм агуу хүчирхэг гурван сэргэлтийг өөр өөр хотуудад болж байхыг нүдээр үзсэн хүн. Гэхдээ энэ сэргэлт бол манай чуулганы хувьд 42 жилд анх удаа тохиолдож байгаа үйл явдал. Бид эдгээр бүхий л жилүүдийн турш Бурханы Сүнс бидэнд асгарахын төлөөнөө залбирч байсан бөгөөд эцэст нь Тэр бидний залбиралд хариулсан. Гэхдээ сүүлийн хэдэн өдрийн орой хамгийн багадаа л 36 хүн гэм нүглийн буруутгалд орж, тэднээс 22 нь аврагдсан – бусад 14 нь сэргэлт аван гэмт нөхцөл байдлаасаа эргэж дахин өөрчлөгдсөн. Энэ сэргэлт нь намайг Исаиа 64:1-3 дугаар зүйлээр дахин дахин номлол хийж, орой бүр хүмүүс сэргэлтийн талаарх “Аврагч минь, миний бүх алсын харааг биелүүлээч, би гуйж байна, Өнөөдөр зөвхөн Есүсийг харахыг зөвшөөрөөч; Аймшигт хөндий дундуур ч гэсэн намайг Та хөтлөөч, Таны гандашгүй алдар намайг хүрээлсэн. Тэнгэрлэг Аврагч минь миний бүх алсын харааг биелүүлээч, Таны алдар дүүрэхэд миний сүнс гэрэлтэх болно. Бүгд харагдтал миний бүх алсын харааг биелүүлээч, Таны Ариун дүр төрх над дээр туссан.” (“Миний бүх алсын харааг биелүүлээч” Avis B. Christiansen, 1895-1985) гэсэн дууг дахин дахин дуулахад тохиох болсон. Сэргэлтийн үед хэдхэн удаа Чөтгөр архирах арслан мэт дайралт хийсэн боловч бид тухай бүр нь залбиран түүнийг зайлуулсан бөгөөд Бурханы Сүнс бидэнд дээр ирэн хүмүүсийг Христ рүү хөтлөн дагуулсан. Эдгээр хэдэн өдрүүдийн турш бид амьд Христэд итгэгчид болон амьд байсан цагтаа хэзээ ч мартахааргүй тийм нөхцөл байдалд байсан тэдгээр хүмүүсийг биеэрээ туулж мэдсэн. Энэ бүгдийн дунд энэ хоёр залуу номлол хийх үүргийг хүлээн авсан. Түүний нэг нь манай хятад хэлний орчуулагчийн хүү Ноа Сонг. Нөгөөх нь Калифорниа Их Сургуулийг дөнгөж саяхан Эрүүгийн эрх зүйн баклавр зэргээр төгссөн 23-хан настай Др Каганы хүү Жон Самуел Каган юм. Энэ хоёр бол үнэхээр гайхалтай номлогчид юм. Жон анхны номлолоо хийх үедээ яг л хорь гаруй жил номлол хийсэн пастор шиг аятай байсан бөгөөд Ноа бол яг л Др Жон Санг болон Др Жон Р. Райс нарын арга барилаар уг сэдэвтэйгээ адил магтууг сонгон аваад номлол хийх зуураа дуулж, тэгээд номлох гэх мэт маш хэцүү зүйлийг хийж байсан. Үнэхээр итгэмээргүй! Эдгээр залуусын төлөө үнэхээр Бурхандаа талархаж байна! Жон Нэгдүгээр сард эхлэх Биологын Их Сургуулийн Талбот Теологийн сургуульд суралцах гэж байгаа. Хэдий тэр гурав дөрөвхөн сар номлож байгаа боловч Доминикан улс, Өмнөд Энэтхэг, Хойд Энэтхэгийн сайн мэдээний цугларалтад номлол хийхээр уригдсан. Тэр хорин нэгдүгээр зууны агуу номлогч нарын нэг адил дэлхийн хэмжээний номлогч болно гэдэгт би огтоос эргэлзэхгүй байна. Хэрвээ та нар Жон эсвэл Ноагийн номлолоос сонсмоор байвал манай www.sermonsfortheworld.com веб хуудас руу зочлоорой. Хар хуудасны дунд хавьд “Sermons in English.” гэсэн товчыг дарвал та нар өөрийнхөө хэл дээрх номлолыг олж харах болно. Хэрвээ тэнд танай хэл дээр номлол байвал та нар Др Химерс, эсвэл Жон Самуел Каган, эсвэл Ноа Сонг, эсвэл манай зочин пастор нарын товчийг дараад харж болно. Хэрвээ тэнд танай хэл дээрх товч байхгүй бол доошоо жагсаалт руу орвол танд хэрэгтэй, таныг ивээх олон номлолуудыг харах болно.

Энэ жилийн хоёр дахь чухал үйл явдал бол миний анхны ач охин Ханна Ким Химерс мэндэлсэн явдал юм. Тэр Гуравдугаар сарын 30-ны өдөр манай хүү Роберт Леслай Химерс III болон түүний хайрт хань Жин нарын гэр

бүлд төрсөн. Ханна маань өхөөрдөм хөөрхөн бөгөөд өөрөө хөл дээрээ зогсоод хүүхдийн орон дотроо бараг л алхаад эхэлсэн байгаа.

Дээр би дурьдсан, Нэгдүгээр сард би эхнэрээ ээж Линдатай нь хамт, Жин, Лесли, Весли нарыг дагуулаад хотоос гадагш Канкун дахь далайн эрэгт амрахаар явсан. Хэдий би хавдрын эсрэг эмчилгээнээсээ болоод нилээд тавгүй байсан ч гэсэн бид үнэхээр цагийг сайхан өнгөрөөсөн. Дашрамд дурьдахад хавдар маань эмчлэгдэхүйц болсон мэт, магадгүй бүр эдгэрсэн ч юм санагдаж байна. Тэр үед нь үүнийг хэлье, гэхдээ би эрүүл мэнддээ тус болохуйц 10 кг орчим жин хасаад байгаа.

Энэ жил тохиолдсон “санамсаргүй олон зүйлсийг” хараарай. Рөүс Ченалт-Квин 97 насандаа Хоёрдугаар сарын 13-ны өдөр нас барсан. Давид Ралстон, Роланд Расмуссен, Данни Томас нар Амилалтын баяр болон миний 75 насны ойгоор номлол хийж, хөгжим тоглож өгсөн. Үүний дараахан Дөрөвдүгээр сарын 16-ний өдөр миний хань Химерсийн төрсөн өдөр болсон бөгөөд 85 настай түүний аав Рафаел Суеллар нисч ирэн хэдэн өдрийг бидэнтэй хамт өнгөрөөсөн.

Тэгээд дараагийн маш том зүйл тохиосон. Бурхан надад чуулгандаа зарим нэг гол өөрчлөлтүүдийг хийх цаг болсон гэдгийг харуулсан. Бид ахлагч нараа Ноа Сонг, Жак Нганн, Аарон Яанци нараар нэмэгдүүлсэн. Жон Каган өөрийнхөө анхны номлолыг Долдугаар сарын 10-нд, Ноа Сонг 17-нд номлосон. Эд нар хоёулаа үнэхээр гайхалтай илтгэгч нар – Итгэмээргүй явдал! Тимоти Чан болон Лара Эскобар нар хуримаа хийсэн. Наймдугаар сарын 21-нд Петр Стефен Нганн мэндэлсэн.

Сэргэлтийн хоёрдугаар хэсэг Наймдугаар сарын 27-ны өдөр эхэлсэн. Эдгээр тусгай цуглаанд бид чухалчлан залбирч, сүнсээр залбирахад Бурханы манай үйл ажиллагаанд оршиж байсан боловч өөр өдрүүдэд бид залбиралд төдийлөн анхаарахгүй болоход Бурхан ерөөсөө байгаагүй бөгөөд юу ч тохиолдоогүй. Хэдий би анхны гурван гол сэргэлт, түүний нэг нь миний явж байсан Хятад чуулганд дөрвөн мянга гаруй хүнийг ирүүлсэн тийм сэргэлтийг харсан хэдий ч энэ нь бидэнд сурууштай туршлага болсон.

Луизиана Баптист Их Сургуулийн ерөнхийлөгч Др Нийл Вийвэр Хөдөлмөрчдийн Өдрийн амралтаар болсон манай Библийн конференцэд бидэнтэй хамт байсан. Арваннэгдүгээр сарын 19-нд Весли Химерс, Кристайн Нгуен, Адейл Менживар, Сетсүко Забалага, Виржел Никел нар баптисм хүртсэн. Мөн тэр өдөр Жон Самуел Каган манай чуулганы Сайнмэдээний номлогч сертификатыг гардан авсан. Дараагийн өдөр нь бид Талархалын баярын өдрийн нийллэгийг Рон Кларк хийл тоглож, Геофф Меррилл төгөлдөр хуур тоглосноор өнгөрөөсөн. Ямар гайхалтай мөч байгаа! Эцэст нь Дэйв Шүүк Арванхоёрдугаар сарын 18-ны өдрийн бидний Христмасын баяраар коунтри болон барууны сайнмэдээний хөгжим тоглохоор энд ирэхээр шийдээд байна.

БУРХАН БИДНИЙ 34 ДЭХ ХЭЛЭЭР НЕПАЛИ ХЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛСНЭЭР НЭГЭН ХААЛГЫГ НЭЭЖ ӨГСӨН. Непал ард түмэн одоо долоо хоног бүр миний номлолыг унших боломжтой болсон. Непалд өнгөрсөн жил хоёр удаа газар хөдөлсөн маш тарчиг ядуу газар бөгөөд Гималай уулсын гүнд орших энэ жижиг улсын хэлээр манай номлол уншигдах болсонд бид туйлаас баяртай байгаа. Одоо миний номлосон номлол бүр шахуу эдгээр 34 хэл рүү орчуулагдан тавигдаж байгаа. Бүх номлолууд маань телевизийн өндөр хүчин чадал бүхий камераар бичигдэн Хятад, Испани, Англи гэсэн гурван хэл дээр дэлхий даяар YouTube болон манай веб сайтаар дамжин түгэж байгаа.

Би үүнийг хүлээн зөвшөөрөх дургүй ч гэсэн би хөгширч байна. Хэдий би ерөөсөө олигтой байгаагүй ч гэсэн өмнөх шигээ бейсболл тоглож чадахгүй байгаа, тиймээс би бас нэг их алдахгүй байгаа. Бүхнээс илүү миний гуниглаж буй зүйл бол энэ юм!!! Талархалын баярын оройн зоогт очих газаргүй манай чуулганы хүн бүрд миний хань их ойр дотно байсан. Бид эдгээр тэмдэглэлт өдрүүдээр үргэлж цагийг сайхан өнгөрүүлдэг.

Энэ гайхалтай Христмасын улирлын турш та нарын амьдрал болон та нарын гэрт Христ илчлэгдээсэй гэдэг нь бидний хүсэл найдвар юм. Та бүгдийг Бурхан ивээх болтугай!



Др Химерс болон Илеана ач охин Ханнагаа төрөөд дөрөв орчим цагтай байх үе.

Есүсийн нэрээр мэндчилсэн,

Р.Л Химерс Жр.,
Др.Үйлч., Др.Теол., Др. УЗох.
Филиппой 4:13

ЗАРИМДАА БҮХ НОМЛОГЧИД НЭГ НОМЛОЛ ДЭЭРЭЭ ГАЦАХ ҮЕ БАЙДАГ. ТА МИНИЙ НОМЛОЛУУДЫГ НЯГТЛААРАЙ, ХЭРВЭЭ ТА ТЭДГЭЭРЭЭС ТУСЛАЛЦАА АВЧ ЧАДАЖ БАЙВАЛ ҮЗЭЭРЭЙ. НИЙ НЭГЭЭС НЭЭС НЭГ НЬ ХА НАР МИНИЙ НОМЛОЛУУДААС ЫГ НЯГТЛААД ҮЗЭЭРЭЙ. ТЭДГЭЭР НЬ ҮҮНИЙ ТУЛД Л ТЭНД БАЙГАА ЮМАА. ОЙРОЛЦООГООР 216 УЛСЫН 120,000 НОМЛОГЧИД МИНИЙ НОМЛОЛЫГ УНШДАГ БӨГӨӨД ЭНЭ ЖИЛ ТЭНДЭЭС ТУСЛАЛЦАА АВСАН. WWW.SERMONSFORTHEWORLD.COM САЙТ РҮҮ ХАНДААРАЙ.



Др Химерс Жон Самуел Каган (зүүн) Ноа Сонг (баруун). Хоёулаа Сайнмэдээний номлогчоор үйлчлэж байгаа бөгөөд теологиор сурах болно.



Жон Каган Сайнмэдээний үйлчлэлийн зөвшөөрөл авах үеэр Др Химерстэй хамт.



Адела Менживар 87 насандаа Др Химерсээр усан баталгаа хийлгэх үеэр.



Др Химерс ноён Виржел Никеллд усан баталгаа хийж буй нь.



Др Химерс гэргийтэйгээ гэр бүл болсоны 34 жилийн ойгоор.



Рафаел Куеллар (3), Лесли Химерс, Жин Химерс Др Химерс, хадагтай Химерс нялх Ханнатай, Жонни Кимийн гэр бүл.

МАНАЙ ЧУУЛГАНЫ WWW.BAPTISTTABERNACLE.COM ВЭБСАЙТАД ЗОЧЛООРОЙ.
МАНАЙ НОМЛОЛЫН WWW.SERMONSFORTHEWORLD.COM ВЕБСАЙТАД ГУЧИН ДӨРВӨН ХЭЛ
ДЭЭР ҮГЧЛЭН ОРЧУУЛСАН НОМЛОЛУУД БАЙГАА.



Жемс Рүүгийн гэр бүл. Эхнэр нь чуулганы органист хөгжимчин.



Др Химерс хадагтай Роус Ченаулт-Күйнтэй хамт.



Марк Букли Др Химерс болон хадагтай Химерстэй хамт Шинэ жилийн өмнөх орой.



Др Чан өөрийн хүү Тимоти болон бэр Лара Ескобар Нарын хуримын ёслолыг удирдаж байгаа нь.



Др Химерс болон хадагтай Химерс нар ээж Линда, Лесли, Весли, Жин Химерс нарын хамт.



(Зүүнээс) Др Химерс нялх Ханна, Лесли, Жин Химерстэй хамт.

**МАНАЙ ЧУУЛГАНЫ WWW.BAPTISTTABERNACLE.COM ВЭБСАЙТАД ЗОЧЛООРОЙ.
МАНАЙ НОМЛОЛЫН WWW.SERMONSFORTHEWORLD.COM ВЕБСАЙТАД ГУЧИН ДӨРВӨН ХЭЛ
ДЭЭР ҮГЧЛЭН ОРЧУУЛСАН ХЭДЭН ЗУУН НОМЛОЛУУД БАЙГАА.**